

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

**Санамж:** Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.

- Энэ хэсэг нь 40 сонгох даалгавар, нийт 80 оноотой.
- Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэг хариулт сонгоорой.
- Сонгосон хариултаа хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.
- Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
- 1-13 дугаар сорилыг эхийн утга санаатай холбон ажиллаарай.

Хүмүүс харцны мөргөлчид /эсээ/

Харц бол ертөнц. Бүхэл бүтэн ертөнц. Гэхдээ яг л хайрын үүр шиг тийм энхрий ертөнц билээ. Харцныхаа салхин дороос хайраа залгилж энэ хорвоо... Нуугдсан хундага шиг харцны өмнө хэчнээн гэмгүй байсан ч гэмтэй юм шиг санагдаад байдаг. Гэгээрсэн хүний харц гэтсэн могойн чимээг ч мэдэрдэг. Гуравдагч нүд магнай дээр яг л булчинтай юм шиг лугшиж оршдог байх аа. Ингэхэд харц өөрөө зүрх сэтгэлийн бурхан нь юм шиг санагдаад байх юм. Тиймээс хайрыг хэн ч цөлж чаддаггүй шиг харцыг хэн ч цөлж чаддаггүй. Тиймээс заримдаа “Харц минь! Нулимс бол чиний нэрсэн дарс биш. Чамаар гагц нэрэгдсэн дарс”

“Зүрх сэтгэлийн ариун язгуур дороос гомдсон хайрын дарс нэрэгддэг юм” гэж учирламаар санагддаг. Тиймээс хэний ч болов харсан газраас сэтгэл зүрхний шарх эдгэрч байх болтугай. Хэн нэгний харцнаас нар мандаад байгаа юм шиг тийм дулаахан санагдахад, хэн нэгний царайнаас сар мандаад байгаа юм шиг тийм гэгээлэг харагдахад, хэн нэгний царайнд одод анивалзаад байгаа юм шиг тийм галтай санагдахад би хэн гэдгээ мартаад, хэн ч биш юм шиг живэн уусах дуртай.

Хоёр нүдний харц хоёр өөр байдаггүй болохоор, хоёр нүүртний зүрх сэтгэлийн хуулинд харц хэзээ ч захирагддаггүй болохоор, харж л байж хүмүүс хайрлаж дурлалцдаг болохоор, хайр харцаараа нөхцөлддөг болохоор харцандаа би хайртай. **Зүрх сэтгэлийнхээ ертөнцөд хөл тавьсан хүмүүс зүйрлэшгүй гэгээн харцтай болдог. Чин сэтгэлтэй хүн гүн харцтай байдаг. Гүн харцтай хүмүүс гүн ухаантай байдаг. Атаа хорслын цагаан хорхой сэтгэл зүрхэнд нь үүрлэсэн хүний харц байнга анивалзаж байдаг. Анивалзан буй харцны цаана атгаг санаа оршин байдаг. Тиймээс харцыг судал. Бүр зорьж судал. Харцны урсгал бол бас нэгэн төрлийн энергийн урсгал мөн. Сэтгэл зүйгээс хамаарахдаа сэрэл мэдрэмжид байнга нөлөөлж байдаг болохоор тэр шүү дээ.**

Хүн ер нь ингэхэд харцны мөргөлчин шиг амьтан л даа. Тиймээс харцны мөргөлчдөд харцны үзэгдлүүд бүхнээс илүү хамаатай байлгүй яах вэ. Харц - мэдрэмж, бодол – сэтгэл, зовлон – жаргал гуравтаа хайнга хандах аргагүй л дээ ерөөсөө.

Гэхдээ харцыг зохиож болдоггүй. Яг л хайрыг зохиож болдоггүй шиг. Харц дотроос төрж, дотоод мөн чанарыг илэрхийлж байдаг болохоор харцандаа хайр нь шингэж, хайрандаа би шингэж байвал болох нь тэр шүү дээ, ер нь. Тиймээс харц хүчтэй. Харцны хүчинд улирал хүртэл багтаж оршдог нь ч мэдрэгддэг. Өвөл шиг харцанд нь даараад байхаар нь би сэтгэл дотроо хаврыг бүтээдэг, хавар шиг харцанд жихүүцээд байхаар нь би сэтгэл дотроо зуныг урьдаг, зун шиг харцанд халууцаад байхаар нь би сэтгэлдээ намрыг авчирдаг, намар шиг харцанд гуниглаад байхаар нь сэтгэлдээн би өвлийг бүтээдэг гэсэн үг л дээ.

П.Хурай



1. Үгийг утгаар нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
 

1) аяглах	а. хол явуулах
2) лугших	б. байн байн аних
3) цөлөх	с. судас дэлсэх
4) нэрэх	д. элдвээр аашлах
5) анивалзах	е. найруулах

А. 1d, 2с, 3а, 4b, 5e      В. 1с, 2d, 3а, 4е, 5b      С. 1с, 2d, 3b, 4а, 5е  
 D. 1d, 2с, 3а, 4е, 5b      E. 1d, 2а, 3е, 4с, 5b
2. “Хүн ер нь ингэхэд харцны мөргөлчин шиг амьтан л даа” гэсэн толгой өгүүлбэрийг дэмжих өгүүлбэр аль нь вэ?
  - A. Тиймээс заримдаа “Харц минь! Нулимс бол чиний нэрсэн дарс биш. Чамаар гагц нэрэгдсэн дарс”
  - B. Тиймээс харцыг судал. Бүр зорьж судал. Харцны урсгал бол бас нэгэн төрлийн энергийн урсгал мөн.
  - C. Тиймээс харцны мөргөлчдөд харцны үзэгдлүүд бүхнээс илүү хамаатай байлгүй яах вэ.
  - D. Тиймээс хэний ч болов харсан газраас сэтгэл зүрхний шарх эдгэрч байх болтугай.
  - E. Тиймээс хайрыг хэн ч цөлж чаддаггүй шиг харцыг хэн ч цөлж чаддаггүй.
3. Эсээний хөтөч санаа аль вэ?
  - A. Харцныхаа салхин дороос хайраа залгилж энэ хорвоо...
  - B. Харц бол ертөнц. Бүхэл бүтэн ертөнц.
  - C. Гуравдагч нүд магнай дээр яг л булчинтай юм шиг лугшиж оршдог байх аа.
  - D. Ингэхэд харц өөрөө зүрх сэтгэлийн бурхан нь юм шиг санагдаад байх юм.
  - E. “Харц минь! Нулимс бол чиний нэрсэн дарс биш. Чамаар гагц нэрэгдсэн дарс”
4. Харцны урсгал бол бас нэгэн төрлийн энергийн урсгал мөн” гэсний учир юу вэ?
  - A. Харцныхаа салхин дороос хайраа залгилж энэ хорвоо оршдог болохоор
  - B. Анивалзан буй харцны цаана атгаг санаа нуугдаж байдаг болохоор
  - C. Хоёр нүүртний зүрх сэтгэлийн хуулинд харц хэзээ ч захирагддаггүй учраас
  - D. Сэтгэл зүйгээс хамаарахдаа сэрэл мэдрэмжид нөлөөлж байдаг болохоор
  - E. Харцны мөргөлчдөд харцны үзэгдлүүд бүхнээс илүү хамаатай болохоор
5. Эхэд дэвшүүлсэн асуудал аль нь вэ?
 

A. Харц бол хайрын илрэл гэдэг тухай	B. Харц бол сэтгэлийн толь гэдэг тухай
C. Харцыг зорьж судлах тухай	D. Харц гэгээн байдаг тухай
E. Харц бол нуугдмал гэдэг тухай	
6. Эхийн гол санааг илэрхийлэх түлхүүр өгүүлбэрийг олоорой.
  - A. Харц зөвхөн хайрын төлөө л урсдаг юм.
  - B. Анивалзан буй харцны цаана атгаг санаа оршин байдаг.
  - C. Сэтгэлийнхээ ертөнцөд хөл тавьсан хүмүүс гэгээн харцтай.
  - D. Харц дотроос төрж, дотоод мөн чанарыг илэрхийлдэг.
  - E. Чин сэтгэлтэй хүн гүн харцтай байдаг.
7. Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг зөв тодорхойлсон нь аль вэ?
  - A. Харцны олон үзэгдлийг учир зүйн дэс дараатай өгүүлж, тоочсон тул тоочимж, хүүрнэмж хосолсон
  - B. Харцны олон үзэгдлийг нэгэн цагт зэрэгцүүлэн тоочсон тул тоочимж
  - C. Харцны олон үзэгдлийн тухай учир зүйн дэс дараатай өгүүлсэн тул хүүрнэмж
  - D. Харцны олон үзэгдлийн учир шалтгааныг тайлбарлан мэдээлсэн тул тайлбарламж
  - E. Харцны олон үзэгдлийн талаар оюун дүгнэлт гарган бичсэн тул эргэцүүлэмж



8. “Хэн нэгний харцнаас нар мандаад байгаа юм шиг тийм дулаахан санагдахад, хэн нэгний царайнаас сар мандаад байгаа юм шиг тийм гэгээлэг харагдахад” гэсэн өгүүлбэрт ямар уран хэрэглүүр байна вэ?
- A. санаагаа аажмаар өсгөн дүрсэлж, хүч нэмсэн тул ахиулал
  - B. эсрэг тэсрэг зүйлсийг сөргөцүүлэн дүрсэлсэн тул харшуулал
  - C. төстэй хэлбэрээр, тэгш эрхтэйгээр зэрэгцүүлсэн тул зэрэгцүүлэл
  - D. ижил төстэй үгсийг сөөлжүүлэн, салаавчлан бичсэн тул сөөлжүүлэл
  - E. сэтгэлийн өнгө аяс, санаагаа гаргахдаа урнаар асуусан тул уран асуулт
9. Аль нь хэлц өгүүлбэр вэ?
- A. Хоёр нүдний харц хоёр өөр байдаггүй.
  - B. Атаа хорслын цагаан хорхой сэтгэлд нь үүрлэсэн.
  - C. Харж л байж хүмүүс хайрлаж дурлалцдаг.
  - D. Чин сэтгэлтэй хүн гүн харцтай байдаг.
  - E. Тиймээс харцыг судал. Бүр зорьж судал.
10. “Чин сэтгэлтэй хүн гүн харцтай байдаг” өгүүлбэрийг тонгоргон хувиргасан нь аль вэ?
- A. Гүн харцтай хүн сэтгэлтэй байдаг.
  - B. Чин сэтгэлтэй хүн гүн гүнзгий харцтай байдаг.
  - C. Гүн харцтай хүн чин сэтгэлтэй байдаг.
  - D. Үнэн сэтгэлтэй хүн гүн харцтай байдаг.
  - E. Гүн харцтай хүн үнэнч сэтгэлтэй байдаг.
11. “Харцныхаа салхин дороос хайраа **залгилж** энэ хорвоо...” өгүүлбэр дэх тодруулсан үгийг солин найруулахад тохиромжтой нь аль вэ?
- A. гударч
  - B. ундаалж
  - C. хугасалж
  - D. гүзээлж
  - E. ууж
12. Доорх нийлмэл өгүүлбэрийн онцолсон хэсэг ямар өгүүлбэр болох вэ?  
**“Зүрх сэтгэлийн ариун язгуур дороос гомдсон хайрын дарс нэрэгддэг юм”**  
гэж учирламаар санагддаг.
- A. шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр
  - B. шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэр
  - C. тодотгол гишүүн өгүүлбэр
  - D. байц гишүүн өгүүлбэр
  - E. өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэр
13. “Тиймээс харцыг судал” өгүүлбэрийг асуух утгатай болгож, зөв бичсэн нь аль вэ?
- A. Тиймээс харцыг судалбал яах вэ?
  - B. Тиймээс харцыг судалбал яахуу?
  - C. Тиймээс харцыг судалбал яах бэ?
  - D. Тиймээс харцыг судалбал яахав?
  - E. Тиймээс харцыг судалбал яахбол?
14. “дагуул үг+цөм үг” гэсэн бүтэцтэй холбоо үгийг олоорой.
- A. галуу шувуу
  - B. ус урсах
  - C. ус мөрөн
  - D. зээрд морь
  - E. бор хоног
15. Хам холбохын “-н” нөхцөлөөр холбогдсон холбоо үгийг олоорой.
- A. хурдан унших
  - B. дөрвөн хөлтөн
  - C. санасан сэтгэл
  - D. алтан намар
  - E. хянан шалгах
16. “дуртай” гэдэг үг үгсийн аймгийн хувьд аль хэсэгт багтах вэ?
- A. зураг, цэцэг, хоол, хичээл
  - B. дурласан, хайрласан
  - C. өглөө, шөнө, орой, үдэш
  - D. өрөвч, ухаалаг, хүнлэг
  - E. учраас, болохоор, бөгөөд



17. Төрөл үгээс бүрдсэн хэсгийг олоорой.  
 А. холдох, холхи, холцруу, холтос  
 В. салаа, салбар, салхи, саланги  
 С. цайрах, цайруу, цайвар, цайдам  
 D. санамж, санаачил, сандрал, санаа  
 E. суумал, суунаг, суумтгай, суутан
18. Хэлц үгээс бүтсэн хэсгийг сонгоорой.  
 А. цагаан цэцэг, ногоон тал  
 В. бараан өдрүүд, хар санаа  
 С. зээрд морь, цагаан сэтгэл  
 D. цагаан шөнө, хангай говь  
 E. үүлтэй тэнгэр, үүлэн борлог
19. Ойрад нутгийн аялгууны “живхлнт” хэмээх үгийг халх аялгуунд зөв буулгасныг олоорой.  
 А. жавхлан В. жаргалант С. жавхлант D. живэхлээр E. жаварт
20. Бүтээврийн нийлцийг ажиглаад, ялгаатай үгийг олоорой.  
 А. хөнгөвчил В. амгайвчил С. нарийвчил D. бүдүүвчил E. хурдавчил
21. Үгсийг утгаар нь зөв харгалзуулсныг олоорой.  
 1. дарх а. үндсээрээ унасан мод  
 2. дархи б. хүчлэх, далдлах, хасах  
 3. дарах с. халдашгүй эрх, эрх мэдэл  
 А. 1а, 2с, 3b В. 1с, 2b, 3а С. 1с, 2а, 3b D. 1а, 2b, 3с E. 1b, 2а, 3с
22. Адил дүрмээр бичсэн үгсийг олоорой.  
 А. оёё, дурсъя  
 В. ирлэе, ерье  
 С. олъё, сольё  
 D. уяя, саная  
 E. танья, ирье
23. Цэгийн оронд утга тохирох үгсийг сонгоорой.  
 “Үзэл ..... дагах ёстой” гэсэн дүрмийг .....  
 А. баримтлаа, баримталлаа  
 В. баримтлаа, баримтлалаа  
 С. баримтлалаа, баримтлаа  
 D. баримталлаа, баримтлалаа  
 E. баримтлалаа, баримталлаа
24. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романы дараах хэсгээс түүхийн хам сэдвийг илтгэх үг хэллэгийг олоорой.  
 Олноо өргөгдсөний дөтгөөр оны зуны эхэн сарын нэгэн өдөр Их Тамирын хойгуур гарсан замаар гуч орчим насны хар хүн нэлээд ачаатай морин тэрэг хөтлөөд явж байв.  
 А. олноо өргөгдсөний дөтгөөр он  
 В. зуны эхэн сарын нэгэн өдөр  
 С. Их Тамирын хойгуур гарсан зам  
 D. гуч орчим насны хар хүн  
 E. ачаатай морин тэрэг хөтлөөд
25. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романы дараах хэсэгт Эрдэнийн ямар зан чанар илэрч байна вэ?  
 Эрдэнэ бусад хүн шиг амьдарч болох байсан ч шинээр ширээ залгасан засаг хаан Гомбожавын зан авир ширүүн, ард олныг зовоох нь хэр хэмжээнээс хэтрэхэд чуулган дарга, монгол манж зургааныг дамжин заргалдав.  
 А. үнэнч итгэлтэй В. заргач шүүмжлэгч С. сайхан сэтгэлтэй  
 D. шударга зарчимч E. өглөгч өгөөмөр




26. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романы доорх орчин нөхцөл нь Эрдэнэд хэрхэн нөлөөлсөн бэ?

Эрдэнийн өөрийн хувьд гэвэл багадаа Доной тайжийн хонь хариулж, хурдан морийг нь унаж байхдаа хүү Чулууны нь бичиг заалгахын далимаар бичиг сурч...	“Оюун түлхүүр”, “Алтан товч”-оос эхлэн, олдсон юм бүхнийг уншин, гуйсан хүнд өргөдөл захиа бичиж, удалгүй “Бичээч Эрдэнэ” гэж нутагтаа алдаршжээ.
---	---

- A. хонь хариулдаг болсон  
 B. хурдан морь унаж сурсан  
 C. бичиг үсэгтэй болсон  
 D. хүнд тусалдаг болсон  
 E. нутагтаа алдаршсан
27. С.Эрдэнэ “Өвгөн шувуу” өгүүллэгийн “Жав гуай тэнгэрийг тооноор, газрыг үүдээр харах төдий болсоор уджээ” гэсэн хэсгээс илрэх санааг олоорой.  
 A. Бие үхэхээс наана ухаан үхчих вий гэдэг айдсыг нь харуулсан.  
 B. Нарыг тооноор, өвс ногоог үүдээрээ харж байгааг нь илэрхийлсэн.  
 C. Дотор нь уужран, толгой нь хөнгөрч байгааг харуулсан.  
 D. Өвчин нь газар авч, гэрээсээ гарч чадахгүй байгааг харуулсан.  
 E. Тэнгэр газраа хүндэтгэн биширч байгаа санааг илэрхийлсэн.
28. С.Эрдэнэ “Өвгөн шувуу” өгүүллэгээс үндэсний ижилсэл буюу монгол хүний зан заншил, сэтгэл зүйн өвөрмөц онцлогийг илэрхийлсэн хэсгийг олоорой.  
 A. Та нар маань нутаг усаа, адуу малаа харж хандаж яваарай.  
 B. Тэгэхэд баг гэдэг чинь одоогийн сум шиг нутагтай байлаа.  
 C. Та нар минь тэгээд үр ач өнөр өтгөн, жаргаж дэгжиж яваарай!  
 D. Шогломоор санагдаад морийг нь хөтлөөд алга болж өглөө.  
 E. Нэг хөгшин буурал азарга сүргээс зайдуу зүүрмэглэн байна.
29. С.Эрдэнэ “Өвгөн шувуу” өгүүллэгт: Жав өвгөний “Сайн ханьтай, голомт залгах хүүтэй, сайхан нөхөдтэй жаргаж явлаа. Ийм тийм юм дутуу дунд байсан гэж гажрах юм алга. Олны дунд л явлаа” гэж хэлсэн нь ямар утгыг агуулж байна вэ?  
 A. Түүний олон найзтай байсныг  
 B. Түүний дутуу зүйлгүй амьдарсныг  
 C. Түүний хангалуун амьдарсныг  
 D. Түүний чинээлэг амьдарсныг  
 E. Түүний зөв амьдарсныг
30. “Хайку” төрлийн шүлгийг олоорой.  
 A. Жин үдийн гэрлийг шөнө дөлөөр ч олж харах  
 Жимс шарилж хоёрын жинхэнэ амтыг ялгах  
 Жирийн бус амьдралд хараатай л яваасай билээ.  
 B. Эзэд ноёд энд хоргой торгонд хөлбөрч байсан  
 Эднүүст элч нар хар хурдаараа ирдэг байсан  
 Өдгөө энэ бүхэн баларч, нурсан балгасны ормон дээр  
 Өнчин хөхөө ганцаараа гүүг гүүг донгодно.  
 C. Алжаан ядрах цагт уулсын оргил түшин амсхийгээрэй  
 Ангах цангах цагт нуур голоос ундлан шамдаарай.  
 D. Мөчрөөс мөчирт  
 Мөлхөн урсах нь  
 Хаврын бороо ажээ.  
 E. Нүдэнд торох бараагүй  
 Нуурын ус цэнхэртэнэ  
 Нүцгэн уулс чимээгүй  
 Өнгөн дээр нь сүүдэртэнэ.




31. Өгүүлбэрийг зөв уншсаныг олоорой.



- A. Монгол хэл бичгийн унаган мэдрэмж, сэтгэхүй сэргэж өгдөг.
- B. Монгол хэл бичгийн унаган мэдрэмж, сэтгэхүйг сэргөөж өгдөг.
- C. Монгол хэл бичгийн унаган мэдрэмж, сэтгэхүйг сэргээж өгдөг.
- D. Монгол хэл бичгийн унаган мэдрэмж, сэтгэхүй сэргэж өгдөг.
- E. Монгол хэл бичгийн унаган мэдрэмж, сэтгэхүйг сэрээж өгдөг.

32. Холбоо үгийг зөв уншсаныг олоорой.



- A. хөөрөнгүй хүү
- B. хөөрхий гүү
- C. хөөрхий хүү
- D. хөөрөх хөө
- E. хөөрхөн гүү

33. “гэнэт” хэмээх үгийг зөв бичсэн нь аль вэ?

- A.
- B.
- C.
- D.
- E.

34. Галигийг үндэсний бичигт зөв буулгасныг олоорой.

“Эхэ хэлэн-ү арбин байан санг”

- A.
- B.
- C.
- D.
- E.

35. “-сан<sup>4</sup>” нөхцөлийг залгасан зүй тогтлыг ажиглаад, тохирох үгийг олоорой.






- A.
- B.
- C.
- D.
- E.

36. “найз” гэсэн үгийг хамаатуулах нөхцөлөөр зөв хувилгасныг олоорой.






- A.
- B.
- C.
- D.
- E.








37. Олноороо үйлдэх утга илэрхийлсэн үгийг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 






38. “үйл үндэс + цагаар төгсгөх нөхцөл” гэсэн бүтэцтэй үгийг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 

39. “үүр” хэмээх үгийг утгаар нь зөв ялгасныг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 

40. “геометр” хэмээх үгийн зөв бичлэгийг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 



## ХОЁРДУГААР ХЭСЭГ

### Санамж:

- Энэ хэсэг нь 4 даалгавар, нийт 20 оноотой.
- Сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, тохирох хариуг будаарай.
- Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Жишээ өгүүлбэрийг нэр томъёотой нь зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3 тоон дээр байгаа нэр томъёо давхцаж болно)

- |                                  |                                     |
|----------------------------------|-------------------------------------|
| a. Тэр дуун их салхийг хүсжээ.   | 1. Хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр   |
| b. Тэнгис далай давлагаална.     | 2. Гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |
| c. Салхи үүлсийг хуралдуулна.    | 3. Цөм бус өгүүлбэр                 |
| d. Далай хүчтэй давлагаална.     |                                     |
| e. Тэнгэр аянга цахилгаан хүснэ. |                                     |

2.2. “Жангар” туулийн жишээг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулаарай.

- |   |              |
|---|--------------|
| a. Арван тавны сар мэт<br>Мандаж суудаг болно.                | 1. юмшуулал  |
| b. Тахийгаад суухаараа<br>Хорин таван хүний зайд суудаг       | 2. тойруулал |
| c. Алтан торлог байшин нь<br>Дугтуй дотор байхлаараа          | 3. ихэсгэл   |
| d. Өл манхан цагаан уул нь<br>Өндөр хөх тэнгэрийн түшиг болох | 4. багасгал  |
| e. Эд мэт эрс нь<br>Энгийн олон баатартайгаа                  | 5. адилтгал  |

2.3. Жишээ үгсийг холбогдох дүрэмтэй нь зөв харгалзуулаарай.

- |               |  |
|---------------|--|
| a. чанар+ыг   | 1. Үгийн үндэс эвдрэх тул балархай эгшгийг гээхгүй бичих үг                    |
| b. эрих+ийг   | 2. Эгшигт гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүрэгтэй балархай эгшгийг гээхгүй бичих үг |
| c. галав+ыг   | 3. Урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгахад ялгах эгшгийг гээхгүй бичих үг          |
| d. бамбар+ыг  | 4. Оноосон нэрийн балархай эгшгийг гээхгүй бичих үг                            |
| e. Сандаг+ийг | 5. Уламжлалын зарчмыг баримтлан балархай эгшгийг гээхгүй бичих үг              |

2.4. Үгсийг дүрсээр ялган, зөв тохируулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 тоон дээр байгаа үгс давхцаж болно)

- |                   |    |    |    |    |
|-------------------|----|----|----|----|
| a. там (диваажин) | 1. | 2. | 3. | 4. |
| b. дэм (тус)      |    |    |    |    |
| c. дам (яриа)     |    |    |    |    |
| d. хайр (нэр үг)  |    |    |    |    |
| e. хайр- (үйл үг) |    |    |    |    |

